



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот


Албан томилолтын зардлын
тариф шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 32,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110,000 төгрөгөөр тус тус шинэчлэн баталсугай.

2. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоолны төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгохыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт зөвлөсүгэй.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЖАВХЛАН

9763000441